

## ЯКУТ, МОНГОЛЫН ТҮҮХ, ХЭЛ, СОЁЛЫН ХЭЛХЭЭ ХОЛБОО

Васильев Юрий Иванович.

Якутын их сургуулийн доцент, дэд эрдэмтэн, Олон улсын түрэг судлалын Академийн академич, ОХУ-ийн Сэтгүүлчдийн холбооны гишүүн, Туркийн зохиолчдын хорооны гишүүн

Ц.Жамбалсүрэн

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** ОХУ-ын Саха (Якутия) ба Монголчуудын хоорондын харилцаа, түүх соёлын нийтлэгийг тодруулах, энэ хоёр ард түмэн өнө эртний удмын хэлхээ холбоотой харуулахыг эрмэлзжээ.

**Түлхүүр үг:** Якут, Монгол, түүх, хэл соёл, зан заншлын нийтлэг

Якут хэмээх үзэсгэлэнт нутаг, тэнд амьдран суудаг ард түмнүүдийн түүх нь ихээхэн нууцыг хадгалж байна гэж хэлж болно. Энэ оньсого болсон гайхамшигт сонин түүхтэй ард түмний гарал, соёлын талаар эрдэмтэд олон янзын таамаглал дэвшүүлсэн байдаг.

Барууны судлаачид: Ф.Страленберг, Я.Линденау нар Якутууд Омогай, Элляя нарын удирдлагаар Буриадаас тусгаарласан гэж үзэв. Тэд үзэхдээ Якутууд Байгалийн хавьд амьдарч (Буриадтай холбоотой байгаад) XVI зуунд Лена мөрний хавьд ирсэн гэв. Нэрт түүхч Г.В.Ксенофонтов "Урианхай-Сахалар" (1937) номондоо Якутууд VII зуунд хойт зүг одсон Хүннүчүүдийн уdam бөгөөд холимог гаралтай гэжээ.

1940-өөд онд С.А.Токарев "XVII-XVIII зууны Якутуудын нийгмийн байгуулал" номдоо якутууд одоогийнхaa нутаг дээр ард түмэн болж бүрэлдсэн гэжээ. "Якутын ард түмэн бүрэлдсэн нь, түүний соёл" гэдэг бүтээлдээ И.В.Константинов үзэхдээ: "Якутууд Байгал хавьд эртний курыкан нараас үүсэн бүрэлдсэн. Энэ курыкан нар нь VI зууны үед Хүннү, Уйгарууд холилдсоны дунд үүссэн. Сүүлд нь Киданы Монгол аймгууд тэдэнд их нөлөөлсөн" гэжээ. Судлаач И.Е.Зыков: якутуудын гол цөм нь эртний түрэг аймгуудын үр садаас үүсэлтэй, түүнд монгол, тунгус аймгууд томоохон нөлөө үзүүлсэн гэдэг санаа дэвшүүлэв. Нэрт эрдэмтэн Л.Н.Гумилев "Саха бол Хүннү нарын дорнод хэсгийнхний үр ач нар" гээд Хүннүг түрэг гаралтай гэсэн санааг дэвшүүлжээ.

Өгүүллийг зохиогчид Хүннү нар монгол аймаг уу, түрэг аймаг уу гэдэг дээр ялгаатай үзэлтэй ч гэсэн Саха, Монголчуудын уdam судар олон талаар нягт холбоотой гэж үзэж байна. Саха, Монгол, Түрэгүүд олон талаар хэлхээ холбоотой нь мэдээж бөгөөд Саха (Якут) үндэстэн бүрэлдэхэд нөлөөлсөн гэж нийтээр үздэг

Хүннүчүүд, буриадууд, Киданы Монгол аймгууд, Байгалийн хавь орчинд амьдарч байсан аймгууд гэдэг нь ихэнхдээ Монгол аймгууд байсан билээ.

Якут хэлийг анхааран судлавал Саха-Монголын түүх, хэл соёлын хэлхээ холбоо тод харагдана. Якут хэл бол БНСаха (Якутия) улсын орос хэлний нэг адил төрийн хэл, Якутын ард түмний үндэсний хэл юм. Бүх Оросын сүүлчийн 2002 оны хүн амын тооллогын мэдээгээр якутчуудын тоо-444 мянга, үүнээс 432 мянга нь Саха (Якутия) улсад амьдардаг. Энэ нь Саха улсын хүн амын 45,5 хувь нь юм. Якут хэл нь хэл зүйн бүтцээрээ эртний түрэг, уйгур хэлэнд их ойрхон юм. Эртний Монгол, Тунгус-Манжуур хэлтэй урт удаан хугацаанд харилцаа холбоотой байсан нь якут хэлний хэл зүй, авианзүйд том нөлөө үзүүлсэн ажээ. С.Калужинский ба В.И.Рассадина нарын тооцоолсноор (нутгийн аялгатай үг тооцохгүйгээр) монгол гаралтай 2500 үг якут хэлэнд байдаг байна.

Якут хэл дээрх анхны ном 1819-1820 онуудад хэвлэгдсэн. 1848 онд А.Я.Уваровскийн “Ахтыллар” (Воспоминания) хэмээх уран зохиолын анхны ном хэвлэгджээ. 1917 онд С.А.Новгородовын анхны якут үсэг бичиг, анхны цагаан толгой “Сурук-бичик” бүтээгджээ. 1935 онд Якут хэл, соёлын хүрээлэн байгуулагдсанаар якут хэлийг бүх талаар судлаж эхэлжээ.

“Якут хэлний аман аялгууны толь”-д монгол гаралтай үг олон бий. Зөвхөн А,Б,Д үсгээр эхэлсэн үгэн дотор 115 монгол үг бий. Эдгээрээс 70 нь нэр үг, 19 нь тэмдэг нэр, 26 нь үйл үг байв. Якут хэл нь бусад түрэг язгуурын хэлнүүдээс Монгол үг хамгийн олонтой хэл юм. Эрдэмтдийн тооцоолсноор наад зах нь 2500-3000 монгол үг якут хэлэнд байдаг ажээ.

Монгол гаралтай үг олон байдгийг дурьдвал: алдьяас буол-алдас болох, бөктүргэ-бөгтөрөг, бүкээг-бүхээг, аврал-абырал, адил атылы, аймаг-аймах, алагала, алгасах-алгаха, алт алтан, аминдай-амыдай, амраг-амарах, амсах-амсай, амт-амтан, ангайх-ангхай, ангархай-ангаархай, анти-анги, ангир-ангыр, андгай-андгай, арал-арал, арзайх-ардай, арилжих-арилдьый, архаг-архах, архи-арыгы, арц-арчы, атаяа-атаан, ах-ага, ахас-агас, аяга-айах, баатар, баатыр, багана-багана, багш-бахсы, балай-балай, балмад-баламат, балт-балта, балчир-балчыр, бараан-бараан, бичиг-бичик, барах-бараа, бардам-бардам, бишрэх-бинирээ, боддо-богдо, билэг-билий, болзоо-болдьох, бөгцгөр-бөкчөгөр, бөх-бөгө, буга-буга, булан-булунг, булчин-былчин, булчирхай-былчархай, буртаг-быртаж, буруу-буруй, бутархай-бытархай, буур-буур, бүдрэх-бүдүрэй, бүлтийх-бүлтэй, бүтэн-бүтүн гэх мэт. Эхний

хоёрхон үсгийг хөнгөхөн ажиглахад монгол үгүүд тэр аяараа байгаа нь олонтаа тохиолдов.

Саха, монголчуудын гадаад төрх, төлөв, менталитет бараг л адил төстэй, нүүдэлчин амьдралын шинжийг одоо ч их хадгалсан, адуу малыг дээдлэн үздэг, айрагт дуртай, бөөгийн шашинтай, зочломтгой, хүмүүнлэг харилцаатай, Чингис хааныг өвөг дээдсээ гэж үздэг зэрэг онцгой чанаруудаас төсөөлөн үзэхэд ойт хээрийн Сахачууд, тал хээрийн Монголчуудын хооронд олон мянган гинжин хэлхээ бий гэж хэлж болно. Энэ талын судалгааг өргөжүүлэх нь эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн их ач тустай юм.

**Abstract:** The article clarifies close ties between Mongolian and yakut people, which can be related to their genesis, language and customs.

### Ном зүй

1. Васильев Н.И. История Якутии. Якутск. 2004, с14-15
2. Рассадин В.И. Монголо-Бурятские заимствования в Сибирских тюркских языках. М., Наука, 1980, с.65
3. Якут хэлний аман аялгууны толь. Якутск, 1990